

## ТЭНГЭРИЙН ОВОО ИХ ХААНЫ БУНХАН МӨН ҮҮ

(Бурхан Халдуны Ихсийн газар дахь  
Монголын Их хаадын оршуулга)

### З.БАТСАЙХАН<sup>1</sup>, Н.ДАВАА<sup>2</sup>, Ж.БОР<sup>3</sup>

<sup>1</sup>МУИС, НШУС, Археологи-Антропологиин тэнхим  
e-mail: batsaihan@num.edu.mn

<sup>2</sup>Тэнгэр угсаа нийгэмлэгийн тэргүүн  
e-mail: davaa@anod.mn

<sup>3</sup>Тэнгэр Угсаа нийгэмлэгийн гүйцэтгэх захирал  
e-mail: khiyad\_borr@yahoo.com

**Түлхүүр үг:** Чингис хаан, Бурхан Халдун, Их хориг, “Гурван гол” були, “МНТ”, “Судрын чуулган”

**ТОВЧ АГУУЛГА:** Өнгөрсөн жилээс хойш бидний судалгааны ажил өргөжихийн хэрээр уг асуудалд шууд болон дам холбогдох шинэ мэдээ баримт олдсон учраас өгүүллийг шинэ хэрэглэгдэхүүнээр баяжуулан засаж, дахин хэвлүүлэх шаардлага гарсан юм.

Х.Пэрлээ, С.Бадамхатан нар Чингис хааны були яг хаана байгааг тогтоож чадаагүй боловч тэдний олон талт судалгаа нь Их Хэнтийг Бурхан Халдун буюу Ихсийн газар, Их хориг мөн гэдгийг ямар ч эргэлзээгүйгээр тодорхойлсон юм.

Түүхэн газар зүй, түүхэн угсаа зүй болон түүхэн ба аман домгийн судалгаа нь Бурхан Халдун ууланд Их хааныг оршуулсан гэх монгол, перс сурвалжийн мэдээг баталж байна. Дунд овооны сүмийн туурийг зарим судлаачид Хэнтий ханд мөргөл үйлдэхэд зориулсан сүм дуган гэж үзсэн боловч уг сүм нь өвөг дээдэст зориулан тахилга, тайлга өргөх өвгөдийн сүм байсныг сурвалжийн мэдээ шууд зааж байна. Зарим мэдээ сэлтийг иш үндэс болговол Их хааныг таалал төгссөнөөс хойш XIX зууны эцэс XX зууны эхэн үе хүртэл Бурхан Халдун уул буюу Хэнтий ханд тасралтгүй 700 гаруй жилийн турш тахилга тайлга өргөж иржээ.

Тал нутгийн нүүдэлчид түрэгийн үеэс эхлээд хаад язгууртнуудаа уулын оройд оршуулах болсон нь түүний дараа дараагийн нүүдэлчдийн оршуулгын зан үйлд уламжлагджээ. Энэ нь сурвалж болон археологийн судалгааны хэрэглэгдэхүүнээр батлагдаж байна.

Тэнгэрийн овоо нь археологийн хэв шинжийн харьцуулсан судалгаагаар эртний були гэдэг нь тогтоогдож байна. Булиийг алс холоос сүрлэг, ихэмсэг харагдах, олон талаараа байгалийн саад бэрхшээлээр хүрээлэгдсэн газар зүйн хувьд хамгийн оновчтой газрыг сонгон байгуулсан байна. Энэхүү асар том байгууламж нь зөвхөн Чингис хааны були байх боломжтой юм.

Бурхан Халдун уулын оройд орших чулуун байгууламжийн талбайд илэрсэн соронзон болон радиометрийн гажлын хэсгүүд давхцаж

*байгаа нь эртний чулуулаг ба були оршуулгатай холбоотой байх магадлалтай гэж ажлын тайланд өгүүлжээ. Энэ нь Тэнгэрийн овоо нь энгийн нэгэн овоо бус, мөн байгалийн тогтоц биш гэдэгт нэмэр хандив болох судалгаа боллоо<sup>1</sup>.*

Монголын нэгдсэн төр улсыг үндэслэн байгуулагч Чингис хааныг хаана, хэрхэн оршуулсан талаар янз бүрийн цаг үед бичигдсэн монгол, перс болон хятад сурвалжуудад тэмдэглэсээр иржээ. Бидний мэдэх дээр дурдсан хэлээр бичсэн олонхи сурвалжид Их хааныг нас нөхчсөний хойно түүний төрсөн нутаг “Турван гол”-ын эхэнд буюу Бурхан Халдун гэх домогт уулнаа оршуулжээ. Энэхүү домогт уулын тухай монголын түүхийн ууган гол сурвалж бичгийн нэг Монголын Нууц Товчоонд (МНТ) олонтаа дурдагдах бөгөөд Чингис хаан болон алтан ургийн холын өвөг дээдэс Бөртэ-чино түүний гэргий Гуа-Марал нар ирж нутагшин Батачи хан хэмээх нэгэн хөвүүнийг төрүүлснээр уг газар нутаг нь язгуурын монголчуудын уугуул нутаг ус болж хожим нь тэнд монголын түүхийн олон чухал үйл явдал өрнөсөн билээ. Чингис хаан хэдий бэр Онон мөрний хөвөөнөө Дэлүүн Болдог хэмээх газарт төрсөн гэх боловч түүний бага идэр нас болон “хойт насны амьдрал” нь Бурхан Халдун уултай салшгүй холбоотой байлаа. Сурвалжид өгүүлснээр Бурхан Халдун уул нь түүний өвөлжөө, хаваржааны нутаг байснаас (Рашид-Ад-Дин, 2002:377) гадна ан авын газар байсан төдийгүй мөн халдах дайснаас дутаан хоргодох тэнгэрлэг нутаг байлаа. МНТ-нд тэмдэглэснээр Тэмүүжин мэргидүүдээс дайжин Бурхан Халдун уулнаа амь хоргодон, эсэн мэнд гарснаар түүнийг үрийн үрд, үүрд тахиж шүтэх андгай тангараг тавьжээ.

Мөн дээрх сурвалжийн мэдээгээр Ихсийн газарт тахилга тайлга өргөж байснаас үзэхүл Бодончураас эхлээд Хамаг монголын хаан Хабул, Амбагай болон Есүхэй баатар зэрэг алтан ургийнхныг нутаглуулдаг байсан бололтой. Гэхдээ сурвалжид яг Бурхан Халдун уулнаа гэж тэмдэглээгүй боловч тахилгын дараа Таргудай Хиралтуг тэргүүтэй тайчууд нар Өэлүн эхийг нутаг дээр нь орхин Онон мөрөн өөд нүүсэн зэрэг үйл явдлыг ажиглахад Бурхан Халдун буюу юу ч атугай “Турван гол”-ын эх газар санаанд бууж байна. Нөгөө талаас хиад аймгийн сурвалжтан ноёдыг тогтсон газар хөдөөлүүлдэг Ихсийн газар буюу Их өтгө нэгэнтээ бий болоод байсныг монгол сурвалжууд батлаж байна.

Судрын Чуулган болоод МНТ, Лу.Алтан товч зэрэг монголын түүхийн гурван гол итгэмжит сурвалжид Их хааныг Бурхан Халдун хэмээх ууланд оршуулсан гэх бөгөөд ялангуяа, Судрын Чуулганд бусад сурвалжаас давуу тал нь дээрх уул хаана оршихыг тодорхой тэмдэглэсэн байна. Тухайлбал: Бурхан Халдун уулын өмнө хормойгоос Кэлурэн (Хэрлэн), Зүүнээс нь Онон, Их зүүн хойноос Киркачу, Их хойноос Чику (Цөх), Их баруун хойноос Калаку (Хилго), Дунд баруун өмнөөс Кара (Хараа), Дунд баруун өмнөөс Бурачиту, Их баруун өмнөөс Дүлэ (Туул) (Рашид-Ад-Дин, 2002:377) зэрэг их бага голууд эх авч урсах бөгөөд эдгээр 8 голын

---

<sup>1</sup>Бидэнд шаардлагатай зарим мэдээ сэлтийн эхийг байгаа газраас нь олж ирж, харамгүй туслалцаа үзүүлсэн профессор Д.Түмэнд талархал илэрхийлье.

нэрсийг ажиглахад Хэрлэн, Онон, Туул, Хараа, Цөх, Хилго зэрэг эдүгээ хүртэл уг нэрээ хадгалсаар ирсэн бидний мэдэх голууд байна. Гэхдээ Онон, Хэрлэн, Туул гэх гурван голыг онцгойлон олонтаа дурьдсан байдаг.

Ийнхүү Бурхан Халдун уул хаана оршин байх баримжаа сурвалжид бий боловч Их, Бага Хэнтий нурууны чухам аль уулыг нь тийнхүү нэрлэж байсан нь мартагдаж, хойч үеийнхэнд тодорхойгүй болсон тул түүнийг олж тогтоох нь судлаачдын нэн тэргүүний зорилт байлаа.

Дундад эртний монголын түүхийг судалсан Д’Оссон (1956), В.Инжиннаши (1978), В.Бартольд (1966), Б.Я.Владимирцов, монголын түүхч А.Амар (1989), Х.Пэрлээ (1963), С.Бадамхатан (1997), Ш.Нацагдорж (1991), өвөрлөгч эрдэмтэн Их мянгадай Ринчин (1987), Р.Сайшаал (1991) нарын зэрэг судлаачдын дотор Их хааныг хаана оршуулсан талаар зөрөөтэй үзэл баримтлалыг дэвшүүлдэг боловч тэр нь ихэнхдээ МНТ, Лу.Алтан товч, Судрын Чуулган, Да Юань улсын түүх гэх мэт сурвалжууд дээр үндэслэн Их, бага Хэнтий нурууны аль нэгэн салбар уул гэж үзэж байлаа. Судлаачдын олонх нь Бурхан Халдун уулнаа Их хааныг оршуулсан гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч олон жилийн турш тодорхой оноож чадаагүй байсан юм. Гэвч тухайн үед уг сэдэв нь дээр дурдсан эх сурвалжийн тодорхой бус бүрхэг мэдээ занги болон газрын зураг төдийхнөөр хязгаарлагдаж байсан бөгөөд нөгөө талаар түүхэн газарзүйн судалгааны ажил үгүйлэгдэж байсан зэрэг шалтгаантай холбоотой нь ойлгомжтой.

1921 онд Судар бичгийн хүрээлэнг байгуулсны дараагаар О.Жамъян гүн, түүхч орчуулагч Л.Дэндэв, Бат-Очир нар хүрээлэнгийн дэргэд “Чингис хааны төрсөн болон онголсон нутгийг тогтоох комисс” байгуулснаар Монгол бичиг, номын хүмүүс албан ёсоор анхаарал хандуулан тухайн үеийн шинжлэх ухааны түвшинд судлаж шинжлэх ажлыг эхлүүлсэн байна. 1926 онд манай Судар бичгийн хүрээлэнгээс оросын нэр хүндтэй монгол судлаач Б.Я.Владимирцовоор ахлуулсан хэл шинжлэлийн экспедицийг Төв, Хэнтий аймгийн нутагт ажиллуулахаар томилон гаргасан байдаг. Тэд нутгийн хэл аялгуу судлахын зэрэгцээ Их Хааныг оршуулсан Бурхан Халдун уулыг битүүдээ эрж, хайж явсан бөгөөд Баатар сүүж хэмээх уулыг мөн бололтой гэж үзжээ (Наваан, 1961:25). Хэрэв өмнө өгүүлсэн уулыг Босго Тэнгэрийн давааны умардад орших Баатар уул мөн гэж үзвэл тэд Бурхан Халдун ууланд нилээд дөхөж очсон байна.

Бурхан Халдун уулыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох судалгаанд манай эрдэмтэд тухайлбал, Х.Пэрлээ, С.Бадамхатан нарын оруулсан хувь нэмрийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Х.Пэрлээ асан 1940-өөд оны адгаас эхлэн МНТ-нд өгүүлсэн Чингис хааны үйл амьдралтай холбоотой түүхэн газар усны нэр, аман түүх, домог сэлтийг судлан шинжлэх ажлыг анхлан явуулсан ажээ. Тэрбээр олон жилийн судалгааны явцад хуримтлагдсан эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан Их Хэнтийг Бурхан Халдун мөн хэмээн урьдчилан дэвшүүлсэн үзэл баримтлалаа улам бататгаад дараахь үндэслэлийг тавьсан байна. Хэнтийн дунд хирд “Дээд тахилга” гэдэг нь байна. Тэнд Хархорумыхтай адил хөх тоосгон барилгын үлдэц байсныг Чингис хааны гуч хүү Гамал Бурхан Халдун ууланд тахилгын сүм бариулсан

мэдээтэй холбон үзсэн, бас Хархорины тогоотой адил гурван хөлт ширмэн тогоо олдсон зэргийг олзуурхан дурдаад Хэнтийн зүүн амаар урсаж буй Богдын голыг эртний Түнхлэг горхин мөн гэж тогтоох үндэслэлтэй боллоо хэмээжээ (Пэрлээ, 1963:72). Хожим нь “Их хориг хаана байна” гэх нэгэн бэсрэг өгүүлэлдээ дээрх үндэслэлүүдийг баяжуулан зарим нэг санааг нэмсэн байдаг бөгөөд тухайлбал, Бурхан Халдун уул нь Гурван голын эхэнд оршиж байгаа, мөн уулын зүүн хойт талын “Их газрын даваа” нь “Иэкэсэ гажар” мөн, Хэнтийн уулыг Өндөр гэгээний (XVII зуун) үед тахиж байсан тул Бурхан Халдунд байсан Их хориг гэгч оршуулгын газруудын улбаа ор мөр бололтой гэжээ (1963:9).

Х.Пэрлээгийн хамт уг аялалд оролцсон германы эрдэмтэн Й.Шубертын аян замын тэмдэглэлд Дунд овооноос гурван хөлт ширмэн тогоо, хүрэл тогооны хагархай, ваарны хагархай, чий будагтай модон аяганы хэсэг, дөрвөн талтай төмөр хадаас болон хавчаар маягийн эд зүйлийг олсноос гадна овооны сүмийн тоосгыг гаргаж овоолон хэд хэдэн газар аль хэдийнэ хүн ухааж түнхсэн бололтой ердийн хайгуулын цооног малтсан байсан тухай тэмдэглэснээс гадна (1963:96) Тэнгэрийн овоонд гарахад ялтсан хуягны хэсгүүд, эртний монголын үеийн сумны зэв ба ламын шашны холбогдолтой зүйлс олон байсныг дурьджээ (1963:97). Түүнчлэн газарч Дамбын хамт 95 м урт, 65 м өргөн, 8 м өндөр чулуун байгууламж үзсэн тухайгаа тэмдэглэсэн байдаг зэргээс үзвэл тухайн бүсэд эртний томоохон хэмжээний оршуулгын байгууламжууд байх магадлалтай болохыг харуулж байна.

Х.Пэрлээгийн эхлүүлсэн энэхүү судалгааг түүний шавь С.Бадамхатан 1983 оноос эхлэн үргэлжлүүлж, түүхэн угсаа зүйн тусгай экспедиц гарган түүхэн газар усны нэрстэй холбогдолтой аман ба түүхэн домог мэдээ цуглуулан 1000 гаруй газар усны нэрс бүртгэн авчээ. Уг судалгааны гол зорилго нь Бурхан Халдун уул буюу Их хоригийг тогтооход чиглэсэн бөгөөд хэдийгээр Их хааныг оршуулсан газрыг олж илрүүлж чадаагүй боловч олон жилийн судалгааны үр дүнг улам лавшруулан Их Хэнтийг Бурхан Халдун уул мөн гэдгийг олон талын эх сурвалжаар ямар ч эргэлзээгүйгээр давхар баталсан нь түүний судалгааны ажлын гол үр дүн байсан. Тэрээр нутгийн аман ярианд Их, Дунд, Бага ба Буурал ахын ам болон Их газрын давааны энгэрт Чингис хаан түүний үр садыг оршуулсан гэдэг домог яриа өргөн дэлгэрснийг (Бадамхатан, 1997:17) дурдаад эдгээр домгууд далд утгаар ямар нэг зүйлийг өгүүлсэн, мөн Их хоригийн дотор буй газар орны нэр Чингисийн онгонтой холбогдсон зэрэг нь Их хориг энэ сав нутагт байжээ гэх бидний таамаглалыг улам итгэл үнэмшилтэй болгож байна гэж онцлон тэмдэглэжээ (1997:19).

Үүнээс гадна МНТ болон Судрын чуулганыг бичиж дууссанаас хойш хэдэн арван жилийн дараа зохиосон Да Юань улсын түүх (1987:78) болон 1378 онд зохиосон “Цо Му Цзи” (Yeh Tze-k'I, 1959) бичиг зэрэгт Чингис хааны шарилыг Чи Нян-гү-д онголов гэснийг В.Инжиннаши Шань-си мужид байх газрын нэр гэж үзсэн байна (1904-1905). Харин Болор тольд “Чингис хааныг Чинэнхүүгийн газар онголлоо. Өгөдэй хааны хүүрийг Чинэнхүүгийн нэрт сүв дор, Хубилай хааныг Чинэнхүүгийн нэрт довцог дор тавив” (1976) хэмээснийг өвөрлөгч эрдэмтэн Ринчин Чи-нян-гу-г МНТ-ны Цэнхэрийн голын Хүрэлх гэж үзэхийн ялдамд Чи-нян-гу бол

монголоор Хүрэлх гэсэн үг гэж тайлжээ (1987:20,49-50). Мөн Р.Сайшаал Бурхан Халдун, Чи-нян-гүгийн талаар тайлбар өгсөн боловч аль нэг талыг илэрхий баримтлаагүй ажээ (1991:914,961-988).

Энэхүү Хүрэлх хэмээх газрын нэг МНТ-нд олонтаа дурдагдахаас гадна мөн Судрын Чуулганд Хүрлү гэж дуудлагаар тэмдэглэгдсэн байх бөгөөд хожим нь Их хааны нэг ордыг тэнд босгосон гэжээ (Рашид-Ад-Дин, 2002:237). Дээрхээс үзвэл Чи-нян-гү гэх нэрийн талаар судлаачид санал нэгдэж чадаагүй байгаа бөгөөд чухам ямар эх сурвалжийн мэдээнд үндэслэн Бурхан Халдуны нэр ийнхүү хувиран өөрчлөгдсөнийг нягтлан үзэх хэрэглэгдэхүүн өнөө хэр олдоогүй байна. Магадгүй дээрх үг нь монгол үгийг хятадаар хазгай тэмдэглэсэн эсвэл монгол үгийн зарим хэсгийг орчуулсан байж болох талтай бөгөөд эдүгээ Их Хэнтий нуруунд Баатар ян, Жодовт ян, Жинст ян, Бэрийн ян, Зангит ян, Битүүгийн ян гэх нэрс гарч буйг хойшид анхааран, нягтлан судлууштай мэт санагдана. Үүний зэрэгцээ Чи Нянгү, Чинэнхүү хоёр нь нэг үгийн хоёр өөр дуудлага байж болох талтай.

Хубилай хааны дэргэд олон жил алба хашсан Марко Пологийн Чингисийн удам угсааны их хаадыг Алтайн их ууланд онголон оршуулдаг гэх нэгэн өөр хувилбарыг С.Бадамхатан Лу.Алтан товчийн мэдээтэй харьцуулаад Алтай ханы ар, Хэнтий ханы өвөр буюу Их ахын нурууны цээжинд орших Алтан өлгий хэмээх энгэр мөн бололтой гэж үзжээ (1997:21). Гэхдээ Лу.Алтан товчийн Алтай ханы арыг Их ахын нурууны цээжинд орших Алтан өлгий хэмээх энгэртэй харьцуулсан нь үнэнд илүү ойр байж болох бөгөөд Шарилт, Бурхант, Алтан өлгий гэх мэт нэртэй газарт эртний булш, бунхан байх нь түгээмэл тохиолддог билээ. Харин Марко Пологийн Алтайн Их уул гэдгийг арай өөр газарт эрж, хайх нь зөв болов уу. Юу гэвэл Судрын чуулганд “Өгөдэй хааны шарил, түүнийг оршуулсан хориотой газар нь мөнх цастай ... гэдэг өндөр ууланд байдаг бөгөөд одоо бол түүнийг ... гэж нэрлэдэг билээ. Тэр уулнаас ... Мөрөн ба ... эх авч урсдаг бөгөөд тэр нь Эрчис голд цутгадаг ажгуу. Уулнаас Эрчис хүрэхэд хоёр өдрийн газар буй” гэжээ (Рашид-Ад-дин, 2002. II:44). Уг мэдээнд тухайн уул болон бусад гол мөрний нэр тэмдэглэгдээгүй боловч Эрчис мөрнөөр төлөөлөн бодоход хамгийн ойр орших өндөр, мөнх цастай уул нь Алтайн нуруу байхыг үгүйсгэх аргагүй.

Хэрэглэгдэхүүнээс үзвэл 1640 онд бичсэн Лу.Алтан товчоос эхлээд Бурхан Халдуны зэрэгцээ Хэнтий хан гэх нэр сурвалжид давхар дурьдагдаж эхэлдэг. Тухайлбал, “Үнэн хүүрийг заримууд нь Бурхан Халдунд онхолов гэх, заримууд, Алтай ханы ард, Хэнтий ханы өвөрт, Их үтгэ нэрт газар онхолов гэх буюу” гэжээ (АТ, 1990:146). Зохиогч дээрх хоёр нэрийг илт өөр өөр уул гэж эндүүрэн ухаж ойлгосон нь эндээс харагдаж байна. Харин 1662 онд зохиосон Саган Сэцэний “Эрдэнийн товч”-д Бурхан Халдун гэх нэр гээгдсэн байдаг бөгөөд чухам энэ үеэс эхлээд аажмаар мартагдан Хэнтий хан гэх нэр зонхилох болсон гэлтэй. Үүнээс гадна Лувсанданзан, Саган Сэцэн нар Ордос нутгийн их бичгийн хүмүүс байсан бөгөөд Бурхан Халдун буюу Хэнтий ханыг нүдээр үзэж хараагүй байхад гайхах зүйлгүй билээ. Гэвч Бурхан Халдун уулын нэр хэрэглэгдэхээ больсон боловч ардын аман домог, хууч яриа, хуучин өчил, сацлын сударт нэр дурдагдсаар иржээ.

Ийнхүү Бурхан Халдун уулыг оновчтой тогтоосноор 2006 оноос эхлэн Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар төрийн тахилгат уул болгон тахиж эхэлсэн билээ. Бурхан Халдун уул нь далайн төвшнөөс дээш 2340 м өндөрт өргөгдсөн, мөстлөгийн явцад үүссэн дэнж бүхий хэд хэдэн тэгш хавтгай оройтой уул юм. Энэхүү дэвсэгийн зүүн хойт захад 22 м өндөр, уртаашаа 280 м, өргөөшөө 190 м, зөв гонзгой хэлбэртэй чулуун байгууламж оршино. Судлаачид Тэнгэрийн овоог энгийн нэг том овоо эсвэл байгалийн тогтоц гэж үзсээр иржээ. Нөгөө талаас бартаа ихтэй уулын оройд оршуулга байх боломжгүй ба Чингис хааны булшийг эртний монголчуудын уламжлалт оршуулгын зан үйлийн дагуу нар тусдаг зүүн тийшээ харсан энгэр газарт байх ёстой гэж үзсэн (Бадамхатан, 1997) нь арга зүйн алдаа болсон гэлтэй.

Сурвалжид өгүүлснээр Чингис хаан нэгэн удаа гөрөөлж яваад ганц модны доор суун ихэд баярлан тайвширсны хойно “энэ чинь намайг хөдөөлүүлэхэд таарах газар байна (Рашид-Ад-Дин, 2002:377). Үүнийг тэмдэглэх” гэснээр тэнд оршуулсан мэтээр бичсэн боловч угтаа түүний хүсэл зоригийг үл харгалзан нас нөхчсөний дараа эртний уламжлалаар хуучин Ихсийн газар оршуулах нь ойлгомжтой юм. Их хааныг оршуулсан хуучин ихсийн газрыг дархлан уг хоригийг (гурук) хамгаалах урианхат аймгийн ноёдыг суулгаснаар Их хориг хэмээх хориотой бүс, хоригчин гэх цэрэг-иргэний үүргийг гүйцэтгэгчдийг нэрлэх нэр томъёо үүссэн бөгөөд яваандаа энэ нь Хориуд хэмээх газар нутгийн нэр болон хувьсан өөрчлөгджээ. Бурхан Халдуны Их хориг нь С.Бадамхатангийн тодорхойлсноор баруун болон баруун хойд талаараа Онон мөрний эх, баруун урдуураа Дэлүүний нуруу болон Босго тэнгэрийн даваа, зүүн хязгаар нь Мөнгөн сардиг уул хүртэлх газар бололтой гэж үзсэн байдаг (1997:12) бөгөөд ойролцоогоор хааш хаашаа 30-40 км талбайд оршиж байгаа юм.

Сурвалж бичигт тэмдэглэснээр монголын зарим хатад тухайлбал, Сорхогтани бэхи болон хан хөвүүдийг Сэлэнгэ мөрний Бүри Өндөр хэмээх ууланд оршуулсан бөгөөд түүнийг ойрадын нэг мянгат сахин хамгаалж байсан тухай тэмдэглэжээ (Рашид-Ад-Дин, 2002.II:228). Түүнчлэн Өгөдэй хааныг хоёр өдөрчийн зайтай газарт орших Мөнх цастай өндөр ууланд (Алтайн нуруу?) оршуулсан бол (Рашид-Ад-Дин, 2002.II:44) ач хүү Хайдуг Или ба Чу голын хооронд орших Шонхорлогт гэдэг их өндөр ууланд нутаглуулж, хориг газрыг охин Хутулун нөхрийн хамт сахин хамгаалж байжээ (Рашид-Ад-Дин, 2002.II:12). Лу.Алтан товчид дурдсанаар бага хаадын нэг болох “Мандуул хааны хүүрийг Мау өндөрт онхолов” гэсэн мэдээ гардаг бөгөөд энэ нь Бурхан Халдун буюу Хэнтий ханы бүс нутгийн ойролцоо оршиж байсан (Алтан товч, 1990) Монгол, Хэрэйд аймгийн хооронд алдарт тулалдаан болсон тэр газар байжээ. Мандуул хаан 1426 онд нас барсан гэж түүх сударт тэмдэглэснээс үзвэл Их хааныг нөхчсөнөөс хойш 200 гаруй жилийн дараа бага хаадыг мөн л Гурван голын сав газарт оршуулах уламжлал тасраагүй байсан ажээ.

Хэрэглэгдэхүүнээс үзвэл тал нутгийн нүүдэлчдийн уламжлалт соёлын хүрээнд тогтмол тахил, тайлга өргөх болон нас нөхчөгсдийг тавьдаг тусгай газрууд

байсан агаад эртний ухуаньд Чишань уул, киданд Абаоцзи (Амбагян), Дэгуан зэрэг хаад, Шулюй хатан нарыг тавьсан Луешань гэх мэт уул байсан ажээ (Таскин, 1984:179).

Зүчийн улс, Цагаадайн улс, Алтан ордны улс болон Ил хаадын улсад алтан ургийнхан болон тэдний хатад, хан хөвүүдийг оршуулдаг тусгай газрууд байсан бөгөөд зарим хаадыг тэр үед хүлээн авсан шашны ёс заншлаар тусгайлан барьсан бунханд оршуулж байсны зарим нь одоо хүртэл тухайн улс оронд хадгалагдан үлджээ.

Их хааныг хэрхэн оршуулсан талаар Судрын Чуулганд тодорхой хэлээгүй боловч тухайн жил өвс ургамал их ургасан олон жилийн дараа өтгөн шигүү ой модоор хучигдсан учир хоригчин нар уг газрыг олохоо больсон гэж бичсэн байдаг (2002:377) бол хятадын Мин улсын үед зохиосон “Цо Му Цзи” хэмээх сурвалжид монгол хаадыг хэрхэн оршуулдаг талаар дараахь байдлаар тодорхойлжээ. “Монголчууд өөрсдийн наснаас нөгчсөн хаадыг оршуулахдаа, хүний чинээ хоёр хэсэг үнэрт модыг ухаж, авс үйлдэн түүний дотор хүүрийг үстэй дээл, малгай өмсүүлж, цагаан өнгийн илгээр хийсэн гутал, оймс, бүсийг хэрэглэн агуулна. Түүний хамт авсны дотор домбо, ваар, пял таваг, цом, халбага, савх зэрэг алтан сав суулгыг тавьсны хойно авсыг битүүлж, дөрвөн алтан цагиргаар бүсэлдэг буй. Хүүр зөөх сүйхийг цагаан эсгий, хивс, хоргойгоор бүтээнэ. Үхээд гурав хоносны хойно оршуулбал зохих газар аваачдаг бөгөөд, авсны өмнөдөд шинэ хувцас өмссөн удган морь унаж, хоргой мэт эдээр жолоо хийсэн, алтаар чимсэн эмээлтэй морь хөтлөн явна. Хүүрийг өдөр бүр гурван удаа хониор тахина. Газрыг гүн ухаж, авсыг булсны хойно хэдэн мянган адуу бэлчээж буюу эсвээс илүү шороог бус газар аваачиж ухсан газрыг тэв тэгш болгоно. Энэ нь ирэх хавар ногоо ургахад булш буй хэмээн огт мэдэгдэхгүй нууц булдаг бөгөөд, бас анх булахад нэг ботгыг түүний эхийн нүдний өмнө алж, мөнхүү газар булдаг бөгөөд, хойд жилийн ойд хүүрийг тахилах мөнөөх ингийг тавьдаг нь тэр буйлан гүйсээр ботгоо булсан газар очдог учир, үүгээр үхэгсдийн булш буй газрыг олдог ажгуу” гэх мэтээр тодорхойлжээ (Амар, 1989:163, Нацагдорж, 1991:170).

Уг тодорхойлолтод эртний нүүдэлчдийн оршуулгын зан үйлийн олон талыг археологийн сурвалжтай харьцуулан үзвэл нилээд үнэн зөв бичсэн болох нь тод харагдаж байна. Гэхдээ хаадыг оршуулсны дараагаар газрыг тэгшлэн хэдэн мянган адуу бэлчээж, мэдэгдэхгүй болгодог гэх мэдээлэл нь анх 1232 онд монголд зорчин явсан хятадын Сүн улсын элч Пэн Да-я-гийн “Хар татарын тэмдэглэл”-д дурдсан байдаг ба “монголчуудын булш овгор шороо байхгүй, тэд булшийг адуугаар гишгүүлж, эрүүл газар мэт харагдах болгодог” гэх мэтээр өгүүлсэн байдаг. Пэн Да-я Чингис хаан нас барсны дараагаар 4-5 жилийн хойно монголд зорчин явж байх үед Их хааныг хаана, хэрхэн оршуулсныг маш их чандлан нууцалж байснаас гадна тэр мэт харийн хүн олон нууц зүйлийг мэдэх боломжтой байсан нь маш эргэлзээтэй юм. Гэтэл үүнийг хожмын ихэнх судлаачид Их хааныг дурдсан байдлаар оршуулсан мэтээр ойлгож төсөөлсөөр байгаа юм. Монгол сурвалжуудад Их хааныг хэрхэн оршуулсан тухай тодорхой зүйлийг тоочоогүй байдаг боловч XIX зууны үед

зохиосон В.Инжиннашийн “Хөх судар”-т нэгэн сонирхолтой бас үнэн байдалд илүү ойрхон мэдээг Х.Пэрлээ (1963), С.Бадамхатан (1997:48) нар иш татан тайлбар сэлт хийсэн хэдий ч тэрхүү тодорхойлолтод төдийлөн ач холбогдол өгөөгүй ажээ. Тухайлбал, “... гуравдугаар хүүрийг Алтай ханы ар, Хант ханы (Хэнтий, Х.Пэрлээ) өрх (өтөг?, Х.Пэрлээ) Дахан уяа (энэ нь Хэрлэн голын нэр, Х.Пэрлээ) мянган газар орд ухан оршуулан баг тэгшилж, чулуун гэр босгож (газар дор, С.Бадамхатан) гэгээн босгов. Дөрөвдүгээр гэгээнийг Бурхан Халдуны өвөр Онон мөрний даланд мөнхүү мянган газрын ордон босгож оршуулан баг тэгшилж, модон гэр (бургасаар овоо босгон, С.Бадамхатан) босгож гэгээний тахилга болгов. Эдгээрийг оршуулахад урьдаар хүрээ шороо унигуул (гуу, Х.Пэрлээ) эрж хэдэн газрыг тойруулан цэрэг бүслэн хааны уг, шадар дөрвөн хүү, дөрвөн хөвүүн, олон ач нар, зургаан чин (сайд, С.Бадамхатан) есөн өрлөгийн ноёд сая оршуулан, хүүрийг тэгшилсэн хойно цэргийг тавин оруулж (газрыг, Х.Пэрлээ) тэгшилнэ” гэжээ (Инжиннаш, 1978:1904-1905). Энэхүү иш татсан хэсгээс үзвэл Х.Пэрлээ (1963), С.Бадамхатан (1997:47,48) нар зарим үгийг андуу ташаа ойлгосон бололтой бөгөөд энэ талаар өөрийн саналыг дурдах нь зүйтэй.

Тухайлбал, “**“мянган газар” гэдгийг алс холоос харагдах, сүрлэг уул; “өрх” гэхийг уулын оройд; “газарт орд ухан оршуулан” гэхийг газар доор бунхан байгуулж; “мод, чулуун гэр босгож” гэхийг газар дээр чулуун байгууламж барьж, “тэгшилж” гэхийг нүхийг бүтүүлэн засав** гэж ойлгож байгаа бөгөөд оршуулгын ажлыг Их хааны ураг төрлийн хүмүүс, шадар сайд нар болон есөн өрлөг, эрэгтэй ач нар гүйцэтгэсэн бөгөөд бүсгүйчүүд уг ёслолын ажиллагаанд оролцоогүй байна. Оршуулгын гол хүнд хүчир ажлыг цэргүүд, магадгүй Их хааны хамгийн итгэлтэй торгон цэрэг хишигтэн, торгуудууд гүйцэтгэсэн бололтой.

В.Инжиннаш алтан ургийн сурвалжит гэр бүлд төрсөн их бичгийн хүн байсан бөгөөд “Хөх судар”-аа бичихдээ монголын түүхийн холбогдолтой арав гаруй эх сурвалж, түүнчлэн бидэнд уламжлагдан ирээгүй олон тооны түүхэн мэдээ баримтыг ашигласан тухайгаа зохиолынхоо оршил хэсэгт дурдсан байдаг. “Хөх судар”-ын дээрх мэдээ нь Их хааныг хэрхэн оршуулсан тухай бидний урьдах ойлголт төсөөллийг залруулах гол тулгуур болно.

Евразийн тал нутгийн нүүдэлчид МЭӨ VII зуунаас эхлэн овог аймгийн тэргүүлэгч хаад сурвалжтан, дээдэст зориулан олон хүний хөлс хүч, хөдөлмөр шингэсэн асар том оршуулгын байгууламжуудыг барьж байгуулсаар ирсэн түүхтэй бөгөөд тэр нь тухайн хүн ямар их нэр цуутай агуу их, хүчирхэг байсны нотолгоо болж, зуун зууныг дамжин нууцаа хадгалан оршиж байдаг билээ. Их хааныг оршуулсан Бурхан Халдун ууланд ийм маягийн байгууламж бий юу гэх асуулт зүй ёсоор гарах ба үүнд Тэнгэрийн овоо гэдэг товчхон хариулт өгч болох юм.

Сүүлийн үед судалгааны ажил өргөжин тэлэхийн хамт өнөөг хүртэл судлаачдын хүртээл болоогүй шууд болон дам холбогдох зарим нэг шинэ мэдээ сэлт олдож байна. Бид үүний өмнөх өгүүлэлдээ английн судлаач С.С.Уолкерийн “Чингис хаан” гэх бүтээлээс Тэнгэрийн овоотой холбоотой нэн сонирхолтой хэсгийг дам иш татсан тухайгаа дурдсан. Саяхан дээрх ишлэлийн уг эхийг олж үзэх



завшаан тохиосон бөгөөд энэ нь Английн Вангийн Газар зүйн Нийгэмлэгийн сэтгүүлийн 1903 оны 11-р сарын дугаарт гарсан К.У.Кэмпеллийн “Монголоор аялсан ану” гэх аян замын тэмдэглэл байсан юм. Тэрбээр, хятадад дипломат ажил хашиж байсан түүх, газар зүйн нилээд өргөн мэдлэгтэй хүн бөгөөд 1902 онд Бээжингээс гарч Хаалган, Дол-нуур, Далай нуур, Буйр нуурыг дамжин явж Хэрлэн голыг өгсөж Өргөө хотод хүрэлцэн ирсний хойно Монголор нийгэмлэгийн төлөөлөгч Фон Грот, түүний найз монгол лам, нэг хятад цэргийн хамт хүрэнээс зүүн зүгт 150 миль зайтай орших Тэрэлжийн (Мөнгөн морьтын) голын алтны уурхайд очиж саатжээ. Кэмпелл Хэнтий хан монголын хамгийн ариун уул болох тухай, мөн Өргөөн дэх манж амбан жил бүрийн намар ирж тахилга, мөргөл үйлддэг тухай монголчуудаас сонсож мэдсэнээ тэмдэглэсэн байх бөгөөд 9-р сарын 21-ний өглөө эрт хөдлөн манж амбаны мөргөдөг гол шүтээн дээр ирэхэд гурван том овооны өмнө утсаар татсан янз бүрийн өнгөтэй туг дарцаг, хар модон тахилгын ширээ болон шавар савтай айраг байлаа гэжээ (1903:513). Түүнчлэн шашны зан үйлд хэрэглэдэг шавар баг, самар, бяслаг, ааруул, хурууд, хадаг болон төвд бичээс бүхий цаас зэрэг хөглөрч байжээ. Эндээс цааш явахад “6 миль (9,6 км) алсад дугуй хэлбэрийн байгууламж байгааг Фон Грот зааж өгсөн бөгөөд уулын оройд гарахад 250 ярд (228,6 м) урт, 200 ярд (182,88 м) өргөн зууван хэлбэрийн булш (tumulus) байлаа. Би үүнийг хүний гараар хийсэн гэдэгт эргэлзэхгүй байна”. Булшны дээр хоёр том чулуун овоо байсан ба нэг овоон дээрээс манж бичээстэй хүрэл бойпорын хагархай олджээ. Бичээсийг хуулан авч Өргөөн дэх Оросын консулын ажилтан М.Долбижаваар (буриад хүн бололтой) уншуулахад Чэн-лунгийн 12 он (Тэнгэрийн тэтгэсний), (1748) гэсэн бичээс байжээ.

Энэхүү ер бусын булш нь магадгүй монголдоо хамгийн том нь байх. Би хувьдаа энэ нь зөвхөн мөргөл тахилга үйлддэг газар гэдэгт итгэхгүй. Харин жинхэнэ Чингис хааны бунхан гэж бодож байна, Фон Грот мөн тэгж таамаглаж байна (Campbell, 1903:514) гэх зэрэг сонирхолтой ажиглалтуудыг хийж явжээ. Замын тэмдэглэлээс үзвэл тэрээр Фон Гроттой эртний танил байсан бөгөөд 1900 онд Монголд алт ухах концесс гэгчийг байгуулах үед ирж байнга оршин суухын зэрэгцээ монгол хүмүүстэй танилцаж, янз бүрийн мэдээлэлтэй болсон нь ойлгомжтой. Ялангуяа, эртний их тахилгат Хэнтий хан уул, түүний дээр орших чулуун байгууламжийн талаар олон зүйлийг сонсож, мэдсэн төдийгүй Кэмпеллийг ирэхээс өмнө очиж үзсэн бөгөөд Өргөөнд ирсний хойно ихээхэн ач холбогдол өгч зорилго болгон буцаж явсан нь монголчуудаас мэдэж авсан ямар нэг ажиг, сэжигийг нүдээр үзэж, дахин нягтлахад чиглэсэн байна. Нөгөө талаар одоогоос 100 гаруй жилийн өмнө Хэнтий ханыг хэрхэн тахиж байсан зэрэг шинэ сонирхолтой мэдээ өгөхийн хамт тухайн үеийн Монгол орны нийгмийг судлахад сурвалжийн хэмжээнд ашиглаж болох шинжлэх ухааны чухал ач холбогдолтой судалгааны хүрээнд ороогүй шинэ хэрэглэгдэхүүн гэдгийг энэ дашрамд дурдъя.

Түүхэн янз бүрийн цаг үед хаад болон томоохон сурвалжит язгууртнуудыг оршуулахад уламжлалт зан үйлийг тэр бүр баримталдаггүй, энгийн иргэдийн булшнаас орших газар, хэмжээ, хэлбэр, хөдөлмөр зарцуулалт гэх мэт олон талаараа

ялгаатай байдаг. Ер нь оршуулгын зан үйлийн практикт газрын хөрсөн дээр шороо, чулуу овоолох гэх мэт ямар нэг байгууламж босгохгүй оршуулах тохиолдол байх боловч тэр нь маш ховроос гадна гол төлөв тухайн хүний үхлийн шалтгаантай холбоотой байдаг. Тэгвэл өрнө, дорнын зарим сурвалжид бичсэнчлэн монгол хаадыг нууцлан оршуулсан, тэр тусмаа Чингис хааныг тийнхүү оршуулсан гэдэг нь үнэнд төдийлөн нийцэхгүй бөгөөд хаадын булшийг хамгаалахын тулд зохиосон цуурхал гэж үзэж болно.

Сүүлийн үед зохион явуулсан археологийн судалгаанаас үзвэл түрэгийн үеэс эхлээд нүүдэлчдийн оршуулгын зан үйлд өөрчлөлт гарч тахилга тайлгын сүрлэг байгууламжууд барьж байгуулахын зэрэгцээ хаадыг алсын бараа харагдах уулын оройд том чулуун байгууламж босгож оршуулах болсон. Үүнд Орхон голын сав дагуух Шивээт Улаан, Шивээт уул, Тарнайн голын байгууламж болон Алтайн нуруунд байгаа томоохон байгууламжуудыг дурдаж болно. Энэ уламжлалын дагуу монголын хаадуудыг өндөр уулын оройд оршуулж байсан нь сурвалжийн мэдээ сэлт болон археологийн хэв шинжийн харьцуулсан судалгаагаар харагдаж байна. Тухайлбал, хэл шинжээч Ш.Гаадамба Монголын нууц товчоог сэргээн сийрүүлсэн эх тайлбартаа “..би бэр өтүлбэ. Нама-ий өтүлжү өндүд-э (өндөр газарт) гарбасу, хагучидба би. Хагучитчу халдуд-та гарбасу” гэсэн өгүүлбэрийн доторх Халдуд-та гэх үг нь өндөрт орших оршуулгын газар гарвал гэсэн утгатай гэж тайлжээ (1990:223). Сүүлийн үед уг судалгаатай холбоотой шинэ сурвалж мэдээ сэлтийг хайн шүүрдэх явцад дээрх асуудлыг нөхвөрлөх сонин мэдээ бас гарч байна. Тавдугаар Богд зохиосон гэж үздэг “Ертөнцөд амьтан буй болж үүссэний сав шим” “Хаадын уг эх ертөнц тогтож, шашин төр үүдсэн зэргийн түүх намтар оршвой” гэх мэт бийрийн бичмэл судруудад “Богд (Чингис хаан З.Б) хорин хоёр он суугаад жаран долоон наснаас шарагчин гахай жилд Сударсун балгаснаа заларч харив. Алтан шарилыг нь Хэнтий ханы оройд залжээ. Эдүгээ Хэнтийн оройд ямар их Богд нар ч заларч болдоггүй амуй. Дарнат богд (Өндөр гэгээн? З.Б) ар, дунд бэлд нь хүрч овоо босгожээ” гээд цааш нь “ ... ач үрээс салж ирсэн Бөрт чоно. Үүний ач үрд төрсөн богд Чингис. Энэ мэт эцэг эх болсон ба эдний хоорондын үе тодорхой байх тул хуурмаг зохиолын шастир бичгүүдийг үнэнд үл баримталтугай” гэх мэтээр олон судар бичгээс үнэн бодит түүхийг голлосон эхийг сонгохыг анхааруулсан нь гэгээнтэн тухайн үеийн сурвалжуудад ихээхэн шүүмжтэй хандаж байсныг харуулах бөгөөд түүний гарт алтан ургийнхны нилээд дэлгэрэнгүй мэдээлэлтэй гар бичмэл, нууц түүхүүд байжээ гэж үзэхэд хүргэж байна.

Хаад, сурвалжтануудыг уулын оройд оршуулах дээрх зан үйл олон зууныг дамжин уламжлагдан ирсэн байна. Тухайлбал, 1. Чин ноён, 2. Хун ван ноён, 3. Манчир ноён, 4. Доглондой ноён, 5. Эрдэнэ Дүүрэгч ноён зэрэг Засагт хан аймгийн сүүлийн таван ноёдыг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг, Шарилын Цагаан уулын оройд дүнзэн бунханд оршуулсан бөгөөд хамгийн эртнийх нь 18-р зууны сүүлд холбогдох бол сүүлчийнх нь болох Эрдэнэ Дүүрэгч ноён 1919 онд нас барсан ажээ (Жуковская, 1990:168-172).

Монгол түрэгүүдийн оршуулгын зан үйлийг тусгайлан судалсан оросын томоохон, эртний судлаачдын нэг В.В.Бартольд “өөрийн удирдагчдыг өндөр газрыг сонгон оршуулах зан заншил нь монголчуудын эртнээс баримталж ирсэн үндсэн ёс жаяг” гэж үзсэн байдаг (1966-т.4:383). Дундад эртний монголчууд үхэгсдийг хөдөөлүүлэхдээ зэрэг дэв, хөрөнгө чинээ, нас хүйсийг нь харгалзан уулын хормой, бэл, энгэр гэх мэт ялгамжтай газрыг сонгон оршуулах бөгөөд уулын орой болон дээд хэсэгт орших булшуудад эд өлгийн чанарын ялгаа ажиглагддагийг судлаачид тэмдэглэжээ.

1990-1992 оны хооронд Чингис хааны онгоныг илрүүлэн тогтоох Монгол, Японы хамтарсан “Гурван гол” төслийн хүрээнд Их хааны үйл амьдралтай холбоотой газруудад цогцолбор судалгааны ажлыг зохион явуулсан. Ялангуяа Их Хэнтий буюу Бурхан Халдун ууланд археологи, геологи, геоморфологи, геоботаник болон геофизикийн цогц судалгаа явуулсан бөгөөд геофизикийн хайгуулыг газар дээр болон агаараас соронзон ба цахилгаан хэмжилтийн аргаар тандан судалсан ажээ. Тандалт судалгаа хийх талбайг уг төслийн монгол талын ахлагч С.Бадамхатан нар японы талтай ярилцан тохирч эхний удаа 14, дараагийн удаад 16 талбайд агаараас цахилгаан соронзон хэмжилт хийхэд 36 сэжигтэй цэг илэрсний ихэнх нь солир унасан, хөрсний эвдрэлтэй, хад асганы нурултай газрууд байсан бөгөөд хэд хэдэн жижиг булш байжээ (Бадамхатан, 1997:28). Харамсалтай нь “Жинхэнэ Бурхан Халдун буюу Хэнтий ханд мөргөл үйлдэн, тахиж байснаас энд хаадыг оршуулж байгаагүй. Үүнийг Хэнтий ханы дунд овооны мөргөлийн сүмийн үлдэц гэрчилж байна” гэж үзсэн. Нөгөө талаас хаадын газар дор бунхалсан булшууд нь Хэнтий ханаас зүүн зүг салбарласан Бага Хэнтий (Мөнгөн сарьдаг), Их Хэнтийн сарьдгууд, Будан, Будан цагаан өвөр, өмнө зүгийн Дэлгэрхаан, Дэлүүний нуруудаас уруудсан урд амнуудын цээжинд, өмнө буюу нар ургах зүг харсан энгэрүүдэд Хэнтий ханыг дэрлэсэн маягаар байх ёстой гэж үзээд (Бадамхатан, 1997:28) геофизикийн агаарын судалгааг зөвхөн уулсын ам хөндийгөөр хийсэн бөгөөд “Гурван гол” экспедицийн японы талын тайланд өгүүлснээр Тэнгэрийн овоо орших уулын зүүн, баруун, урд энгэр болон Богдын голын дагуу тандан судалжээ (Gurvan Gol, 1994:76).

Монгол, Японы хамтарсан “Гурван гол” төслийн судалгаа нь хээрийн судалгааны арга зүйг алдаатай томъёолсноос үүдэн өмнөө тавьсан зорилгоо амжилттай хэрэгжүүлж чадаагүй боловч монголын археологийн судалгаанд олон шинэ мэдээллийг бий болгосон. Ялангуяа, Их хааны булш хаана байж болох эцсийн цэгүүдийг тогтоож өгснөөс гадна өрнө, дорнын зарим сурвалжид тэмдэглэсэн нууцлан оршуулсан гэх мэдээг нэг талаас няцаасан судалгаа болсон юм.

Бидний зохион явуулсан судалгаа нь дээр өгүүлсэн олон арван жилийн судалгааны ажлын шууд үргэлжлэл байсан гэдгийг юуны өмнө онцлон тэмдэглэх хэрэгтэй. Судалгааны явцад археологийн харьцуулалт ажиглалтын аргаас гадна монгол, хятад, перс сурвалжуудын мэдээ занги болон холбогдох судалгааны зохиолуудыг дахин нягтлан үзсэний эцэст Их хааныг нууцлан оршуулаагүй гэдэг дүгнэлтэд арга буюу хүрсэн бөгөөд Бурхан Халдун уулын оройд орших Тэнгэрийн овоог Чингис хааны булш гэж үзлээ. Уг таамаглалыг лавшруулахын тулд эдүгээ

геологийн хайгуулын судалгаанд хэрэглэж буй орчин үеийн геофизикийн тандалт судалгааны багажаар Тэнгэрийн овоонд 108 цэгт соронзон болон радиометрийн хэмжилт судалгаа хийхэд дээрх овооны зүүн хэсэгт соронзон орны ажиглалтаар төмөр байж болохуйц 3 илэрц илэрсэн бөгөөд хэмжилтийн утга нь ердийн түвшингөөс харьцангуй их 59200 нанотесло байлаа. Овооны бусад хэсэг болон ойр орчимд радиометрийн ба соронзон гажил ажиглагдахгүй боловч талбайн баруун ба зүүн хэсэгт орчны радио идэвхижилт өндөр ба зүүн хэсгийн цацрагжилт төвдөө 20 м-ээс баруун тал руу 100 м гаруй сарнин тархсан байна. Талбайд илэрсэн соронзон болон радиометрийн гажлын хэсгүүд давхцаж байгаа нь эртний чулуулаг ба булш оршуулгатай холбоотой байх магадлалтай гэж ажлын тайланд өгүүлжээ (Геофизикийн тандалт судалгааг “Нефрит” ХХК хийсэн). Энэ нь Тэнгэрийн овоог энгийн нэгэн овоо бус, мөн байгалийн тогтоц биш гэдэгт нэмэр хандив болох судалгаа болсон юм.

Эцэст нь тэмдэглэхэд Х.Пэрлээ, С.Бадамхатан нар Чингис хааны булш яг хаана байгааг тогтоож чадаагүй боловч тэдний олон талт судалгаа нь Их Хэнтийг Бурхан Халдун буюу Ихсийн газар, Их хориг мөн гэдгийг ямар ч эргэлзээгүйгээр тодорхойлжээ.

Түүхэн газарзүй, түүхэн угсаа зүй болон түүхэн ба аман домгийн судалгаа нь Бурхан Халдун ууланд Их хааныг оршуулсан гэх мөнгөл, перс сурвалжийн мэдээг баталж байна.

Дунд овооны сүмийн туурийг зарим судлаачид Хэнтий ханд мөргөл үйлдэхэд зориулсан сүм дуган гэж үзсэн боловч бидний бодлоор уг сүм нь өвөг дээдэст зориулан тахилга, тайлга өргөх өвгөдийн сүм байсан ажээ. Сурвалжид Хубилайн гуч хүү Гамалын тухай “...Бурхан Халдун зэргийг бүгдийг тэр мэдэн захирч, мөн урьдын адил тэнд байдаг агуу их буурь, бууцыг хамгаалж байх болгосон. Тэдгээр нь тэнд бүгд ес байдаг. Дөрвөн том суурь, буурь бууц бас (дахин) тав буй. Тийшээ хэн ч явах учиргүй учир ойролцоо дархалсан газар (Их хориг) тэр тэнд (өөд болсон өвөг дээдсийнхээ) дүрийг хийсэн ба тогтмол анхилам үнэртэй хүж арц шатаан уугуулан, сан тавьж байдаг болгосон ажээ. Гамал тэнд бөөгийн мөргөлийн сүм бариулжээ” (Рашид-Ад-Дин, 2002, II:234). Өмнө өгүүлсэн дөрвөн их буурь бууц гэдэг нь Чингис хаан, Тулуй, Мөнх болон Хубилай зэрэг Их хаадын булшийг хэлж байгаа бололтой. Судрын чуулганд Аригбухаг Бурхан Халдунд оршуулсан гэхийн зэрэгцээ мөн Сэлэнгийн Бүри Өндөрт оршуулсан гэж давхардуулан бичсэн байдаг (2002, II:228). Аригбуха хэдийгээр Тулуйн бага хүү байсан боловч том ах Хубилайн эсрэг хаан ширээний төлөө тэрсэлдэн, тэмцэлдэж байсан зэргээс үзвэл түүнийг Бурхан Халдуны Их хоригт оршуулаагүй байх бүрэн үндэстэй. Харин ямар шалтгааны улмаас Өгөдэйг өөр газарт оршуулсан нь их бүрхэг ээдрээтэй асуудал билээ.

Дээрх тахилгын сүмийг 1294 онд Хубилай хааныг нас нөгчсөний дараагаар байгуулсан мэтээр сурвалжид бичсэн боловч түүнээс өмнө тахилга явуулж байсан газрын буурин дээр дахин байгуулсан байж болох талтай. Энэ нь Өвөр монголын нутагт малтан судалсан кидан язгууртнуудын бунхант булш орших амны эхэнд

тахилгын сүм байдагтай төстэй байгаагаас гадна эртний түрэгүүд хаад, сурвалжтануудад зориулсан тахилгын газарт сүм байгуулан дайн тулааны алдар гавъяаг нь харуулсан туурганы зургийг хийж бүтээж байсан тухай Кюльтегины хөшөөнд бичсэн байдаг. Энэ бүгдийг эрэгцүүлэн үзвээс Тэнгэрийн овоонд ямар нэг сурвалжит хүний булш бий гэдгийг дам зааж буй хэрэг мөн. Энд Их хааны удмын охин үрс, хатад, бэрүүд мөргөл үйлдэн тахилга өргөх бөгөөд монгол уламжлалт ёс заншлаар бүсгүйчүүд оршуулгын газарт очдоггүй мөн оролцдоггүй байснаар төсөөлж болох юм.

Эцэст нь Ертөнцийг байлдан дагуулагч 1227 оны 8-р сарын 25-нд шарагчин үхэр өдөр 66 насандаа Лю Пань Шань уулын орчим дахь Цин Шуй Сяньий Си Цзянд нас барахад олон хүлгээр чирүүлсэн хам их тэргэнд тээж Мони уулыг дамжин 3 сар явж Саарь хээрийн Халиутайн ордонд ирэх хүртэл түүний “алтан” шарилыг хэрхсэн тухай болно. Тухайлбал, монголчууд скиф, кидануудын мэддэг байсан шарилыг занданшуулах аргыг мэддэггүй байсан бөгөөд Монголын эзэнт гүрний үед ч хаадаа зандалшуулж байгаагүй (Wittfogel:280) гэсэн нилээд эргэлзээтэй дүгнэлт хийснийг зарим судлаачид түүхэн үндэстэй гэж үзсэн байдаг (Рачневский, 2006:99,100). Ийнхүү эргэлзэх болсон шалтгаан нь Саган Сэцэний “Эрдэнийн эрхи”-ийн талаар судалгаа хийсэн Шмидт Их хааны “биеийг” уугуул нутагт нь бүрэн бүтэн авч ирээгүй, зөвхөн хэсэгхэн үлдэгдлийг монголд бунхалсан гэж үзжээ. Тэрбээр “... алтан биеийг нь гаргаж ядан цөхрөөд ” гэх хэсгийг авсыг хоосон байсан мэтээр ухаж ойлгосон нь (Рачневский, 2006:99,100) ийнхүү дүгнэлт хийхэд хүргэжээ. Гэтэл энд хоосон байсан гэх ямар нэг санаа цухалзахгүй байгаа бөгөөд харин “Төдий эзний алтан хүүрийг нь Алтай ханы ар, Хэнтий ханы өлгөд Их өтгө нэрт газраа онголбой” хэмээн үргэлжилдэг билээ (Эрдэнийн товч, 2006:89).

Скифүүд болон киданууд монголчуудын нэгэн адил нүүдэлчид байсан бөгөөд аж ахуй, соёл болон хөгжлийн хувьд ойролцоо төвшинд байсныг бид мэднэ. Иймээс Дундад эртний монголчуудыг хоцрогдсон, бүдүүлэг, дорой байсан мэтээр ойлгож, төсөөлөх нь ихээхэн эндүү ташаа ойлголт юм. Ялангуяа киданууд судлаачдын үзэж байгаагаар монголчуудтай угсаа, гарвал нэгтэй аж ахуй, соёлын хувьд адил нүүдэлчин ард түмэн байсан боловч шарилыг занданшуулах аргыг мэддэг байсныг сурвалжид тодорхой бичиж тэмдэглэжээ. Тухайлбал, Дэгуан хааны тухай хятадын “Таван төрийн түүхэн”-д “Луаньчэн хотод хүрсний дараа Дэгуан хүндээр өвчилж Шахулин төгөлд нас барав. Киданууд түүний дотор эрхтнийг авсны дараа хоосон хөндийг давсаар дүүргэн хүүрийг тэргэнд ачиж, умар зүг авч одсон” бөгөөд 947 онд өвгөдийг нутаглуулдаг Муешань ууланд их тахилга үйлдэн оршуулжээ (Таскин, 1984:205,208). Түүнчлэн Жамбалдоржийн “Болор толь”-д Ертөнцийг байлдан дагуулагчийн шарилын тухай нилээд хэтрүүлэгтэй боловч сонирхолтой мэдээ гарч байна. “ Чингис хааныг тэнгэр болсон цагт шарилыг үзвээс солонго мэт мяралзаад нэгэн тохой хиртэй болсныг бүгдээр үзэж, гайхалдан олон түшмэл ба хатад, хүүхэд зөвлөлдөн хэлэлцэж, алтан хайрцагны дотор залаад тэнгэрийн орд харш мэт байдалтай цомцог хэмээх ордонд оршуулж тахиваа” (1984:422) гэсэн нь хааныг зандалшуулсаныг хэлж байгаа бололтойгоос гадна тохой


хирийн болсон гэдэг нь дахин төрөхийг ёгт байдлаар илэрхийлсэн байна. Юу ч атугай Их хааны шарилыг олон хоног сарын турш энгийн байдлаар хадгалан эх нутагт хүргэж ирсэн гэж үзэх нь хэтэрхий гэнэн ойлголт болох нь тодорхой юм.



*Зураг 1. Тэнгэрийн овоо. 2-р дэвсэг дээрээс авсан зураг*



*Зураг 2. 4-р дэвсэг дээрээс авсан зураг*



*Зураг 3. Нисдэг тэрэгнээс авсан зураг. Зүүн хойд талаас*

Сурвалжийн мэдээгээр анх Боорчи ноён Чингис хааны булш бунхныг тахиж байх санал, санаачилга гаргасан хэмээн дурдсан байхаас гадна Өгөдэй хааны үед жилд нэг удаа тахиж байсныг Хубилай хааны үед жилд дөрвөн удаа тахиж байхаар болгосон бөгөөд тахилга хийх сар өдрийг тодорхой заасан байдаг байна.

Их хааныг бунхалсан Бурхан Халдун уулыг хоригчид сахин хамгаалж байсан бөгөөд хоригчид Тэнүүний голоос эхлээд Босго тэнгэрийн давааг дамнан Бурхан Халдун уул хүртэлх хөндий дагуу сууж байсан бололтой.

Дунд овоонд өвгөдийн тахилгын сүмтэй байсан нь нэгэн цагт эвдрэн нурсан боловч XIX зууны эцэс XX зууны эхэн үе хүртэл тасралтгүй 700 гаруй жилийн турш тахилга, тайлга өргөж иржээ.

Олон төрлийн сурвалжийн мэдээ сэлтийг харьцуулан үзэхэд нүүдэлчид хаад, сурвалжтан нараа уулын орой, өндөрлөг хэсэгт “тэнгэрт ойр” бунхлан оршуулж, ойр орчим нь тахилга, тайлгын газрыг байгуулдаг байжээ.

Тэнгэрийн овоо нь археологийн хэв шинжийн харьцуулсан судалгаагаар эртний булш гэдэг нь тогтоогдож байна. Булшийг алс холоос сүрлэг, ихэмсэг харагдах, олон талаараа байгалийн саад бэрхшээлээр хүрээлэгдсэн, газарзүйн хамгийн тохиромжтой, хамгийн оновчтой газрыг сонгон байгуулсан байна.

Энэхүү асар том байгууламж нь зөвхөн Чингис хааны булш байх боломжтой бөгөөд эдүгээ аугаа их сүр хүчний билэгдэл болон олон зууныг дамжин сүрлэг, ихэмсэг оршсоор байна.

### **НОМ ЗҮЙ**

*Амар А.*, 1989. Монголын товч түүх. УБ.

*A report on the joint investigation under the Mongolian and Japanese “Gurvan gol” historic relic probe project (1991-1993).* Mogolian Academy of Sciences and The Yomiuri Shimbun, Japan

*Бадамхатан С.*, 1997. Чингис хаан: “Энд би нойрсоно”. УБ.

*Бартольд В.*, 1966. К вопросу о погребальных обрядах турков и монголов. Т.IV.M.

*Гаадамба Ш.*, 1990. Монголын Нууц Товчоо. Худам (язгуур монгол) монгол бичгээр монгол бичиг, утга зохиолын үүднээс сэргээсэн сийрүүлэг эх. УБ.

*Да Юань улсын түүх.* Хөх хот, 1987

*Жамбалдорж.*, 1976. Болор толь. Хөх хот.

*Жуковская Н.Л.*, 1990. Некоторые нойоны Дзасактухановского аймака (Северная Монголия). Археологические этнографические и антропологические исследования в Монголии. Новосибирск.

*Инжиннаш В.*, 1978. Хөх судар. III дэвтэр. Хөх хот.

*Инжиннаш В.*, 2005. Хөх судар. III боть. УБ.

*Лувсанданзан.*, 1990. Алтан товч. УБ.

*Монголын Нууц Товчоо.* УБ, 1990

*Наваан Д.*, 1961. Өвгөн Дэндэвийн дурдатгал. УБ.

*Нацагдорж Ш.*, 1991. Чингис хааны цадиг. УБ.

*Оссон Д.*, 1956. Монголын түүх. Хөх хот.

*Пэрлээ Х.*, 1963. Их хориг хаана байна. УБ.

*Пэрлээ Х.*, 1963. Монгол-Ардчилсан Германы шинжилгээний ангийн тухай. УБ.

*Рачневский П.*, 2006. Чингис хаан ба түүний амьдрал ба өв. УБ.

*Рашид-Ад-Дин.*, 2002. Судрын Чуулган. УБ.

- Ринчин Б.*, 1987. Ци нян гу болон Хүрэлх, Өвөр Монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.
- Саган Сэцэн.*, 2006. Эрдэнийн эрхи. УБ.
- Сайшаал Р.*, 1991. Чингис хааны товчоон. II дэвтэр. Хөх хот.
- Уолкер С.С.*, 2001. Чингис хаан. УБ.
- Campbell C.W.*, 1903. Journeys in Mongolia. The Geographical Journal, Vol.22, No.5 (Nov., 1903), pp.485-518
- Schubert J.*, 1963. Ritt zum Burchan chaldun. Forschungsreisen in der Mongolischen Volksrepublik. Leipzig.
- Y'eh Tze-K'i. Ts'ao-mu-tze.* Shanghai, 1959

SUMMARY

**З.Батсайхан, Н.Даваа, Ж.Бор**

**IS TENGERRIIN OVOO A BURIAL OF CHINGGIS KHAAN?**

Based on the results of the autopsy analysis of the Chinese and persian historical sources and continuous research conducted by Kh.Perlee and S.Badamhatan on historical geography and anthropology leave no doubt that Chinggis Khaan was buried in the Great Khentii's Burkhan Khaldun mountains.

Prolonged and extended research carried out by Mongol-Japanese "Gurvan gol" project team to find Chinggis Khaan's burial in 1990-1992, particularly a sophisticated geophysical research helped to reveal that the indication of the sources that The Khaan was buried in great secrecy is far from being trustworthy information.

Based on the Chinese and Persian sources, and the results of the archaeological, ethnological studies and the geophysical researches conducted by 2 different methods in 108 spots of the "Ikh Owoo" enables us to conclude that Ikh owoo of the Burkhan Khaldun mountains could be the burial of the Chiggis Khaan.